

**БАТЛАВ.**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Д.ГАНБАТ**

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг "Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайллан хамгаалбал зохих нууцад хамаarahгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй", Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д "төрийн алба ил тод байх", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д "төсвийн ил тод байдлыг хангасан байх" зарчмыг, түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3 дугаар бүлгийн 3.1.12-д "Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ" гэж тус тус заасан.

Ийнхүү дээрх хууль тогтоомжийн зарчмыг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах зорилгоор Төсвийн болон төрийн, төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн байдлын ил тод "Шилэн данс"-ны тогтолцоог сайжруулах, хэрэгжилтийг хангуулах үүднээс хариуцлагын тогтолцоог сайжруулах, хууль хэрэгжүүлэх хөшүүргийг бий болгох зорилгоор төслийг боловсруулах шаардлагатай байна.

**1.2. Практик үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн боловч хариуцлагын тогтолцоог бүрэн хуульчилж өгөөгүйгээс хууль биелүүлээгүй, зөрчсөн, зөрчил гаргасан этгүүдтэй хариуцлага тооцох механизм орхигдсон байна. Хуульд заасан байгууллагууд болон албан тушаалтууд шилэн дансны мэдээллээ хуулийн хугацаандаа оруулахгүй байх, дутуу оруулах, санаатай худал мэдээлэл оруулах, засварлах зэрэг хууль бус үйлдлүүд гарсаар байгааг таслан зогсоо шаардлага зүй ёсоор үүссэн.

Өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой аливаа шийдвэр /тогтоол, тушаал/, үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, мөнгөн гүйлгээтэй холбоотой мэдээллүүд олон нийтэд хаалттай хэвээр байна. Хариуцлага алдсан албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хэн хяналт тавих, хууль зөрчсөн албан тушаалтанд ямар журмаар, хэн, ямар хариуцлага хүлээлгэх асуудал тодорхой биш, хуулийн хэрэгжилтийг хангах механизмтай холбоотой зохицуулалт алга байна.

Шилэн дансны тухай хуулиар шилэн дансны мэдээлэлд оруулж байх мөнгөн дүн 5 сая төгрөгөөс дээш дүнтэй байгаа нь хариуцсан албан тушаалтнууд хуулиар тогтоосон босгыг давуулахгүйгээр зардлаа хувааж зарцуулалт хийх байдлаар буруу арга хэрэглэж, төсвийн зарцуулалт ил тод, шударга байж чадахгүй байгаа тул энэ дүнг багасгаж нэг сая төгрөг болгох, төсвийн зарцуулалтыг бодитоор ил болгох шаардлагатай байна.

Үндэсний Аудитын газрын 2019 оны шилэн дансны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайланд “Шилэн дансанд бүртгэлтэй 7944 байгууллага, хуулийн этгээд байдаг ба 5811 нь төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгаа гэв. Аудитад 6463-ыг нь хамруулсан. Хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ 54.5 хувьтай хэрэгжүүлсэн, баг, хороо, иргэдийн нийтийн хурлаас хяналтыг хэрэгжүүлэхгүй байна. 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутаг, төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалт байхгүйтэй холбоотой” гэж дүгнэлт гаргасан байгаа нь энэ хуульд хариуцлагын тогтолцоог нэн даруй зохицуулах шаардлагатайг илтгэж байна.

Иймд дээрх шаардлагуудыг үндэслэж Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд таван сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг нэг сая болгох, мөн хариуцлагыг тухайлан зааж өгөхөөр боловсрууллаа.

**Хоёр. Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ.**

Шилэн дансны тухай хуульд заасан байгууллага, албан тушаалтанд энэ хуулийн төсөл хамаарна.

Энэхүү хуулийн төслөөр нэг сая төгрөгөөс дээш төсвийн орлого, зарлага, мөнгөн гүйлгээ, тайлагнах үйл ажиллагаа болон өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, иргэдэд ойлгомжтой, шуурхай мэдээлэх, хуульд заасан үйл ажиллагаагаа

хэрэгжүүлээгүй байгууллага, хариуцсан албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

**Гурав. Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар**

Улс болон орон нутгийн төсвийн орлого, зарцуулалт, мөнгөн гүйлгээ, тайлант болон өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр, үйл ажиллагаа “цогц байдлаар” олон нийтэд нээлттэй, ил тод болно. Мөн иргэний хяналтын тогтолцоо бүрдэж, татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах төсвийн удирдлагын тогтолцоо бүрдэхэд томоохон нөлөө үзүүлнэ.

Мөн хууль хэрэгжүүлдэггүй албан тушаалтнуудын хариуцлага сайжирна. Иргэдийн төсвийн зарцуулалтад тавих улам сайжирснаар төсвийн зориулалтын бус, үрэлгэн зардлуудыг илчлэх, улмаар хариуцлага тооцох нөхцөл бүрдэнэ. Шилэн дансаа хөтлөөгүй төрийн байгууллага, албан тушаалтнуудад хариуцлага тооцох, улмаар хууль хэрэгжүүлэх байдал сайжирна.

**Дөрөв. Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд**

Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль, тэдгээрийн үзэл баримтлал, агуулга, зарчимд нийцэж боловсруулсан ба бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--- оОо ---

ХУУЛЬ САНААЧЛАГЧ